




**Хүснэгт 1. Анхдагч захын голлох үзүүлэлт (2021.03.31)**

Хэрэгсэл	ТБҮЦ	
Хугацааны төрөл	4 долоо хоног	28 долоо хоног
Хүүний түвшин	Бодлогын хүү	Бодлогын хүү+0.5 нэгж хувь
Арилжааны төрөл	Тогтмол хүүгээр, хэмжээ хязгаарлахгүй	Хүүгээр өрсөлдөх, хэмжээ хязгаарлах
ТБҮЦ-ны үлдэгдэл (Тэрбум ₮, 2021.03.31)	8460.3	235.0
Улирлын дээд/доод утга (Тэрбум ₮)	8669.3/7461.4	295.0/235.0
Улирлын өөрчлөлт (Тэрбум ₮)	12.8% (+1064.4)	-6.4% (-15.0)
Сарын өөрчлөлт (Тэрбум ₮)	-1.1% (-92.5)	-17.0% (-40.0)
Оны эхнээс өөрчлөлт	12.8% (+1064.4)	-6.4% (-15.0)

Эх сурвалж: Монголбанк

**Дүрслэл 1. Төв банкны үнэт цаасны хэмжээ (Тэрбум ₮, 2021.01 дүгээр улирал)**




Эх сурвалж: Монголбанк

**Хүснэгт 2. Банкны системийн активын хэмжээ (Их наяд. ₮)**

Үзүүлэлт	2020.12.31	2021.03.31	Өөрчлөлт, оны эхнээс (₮)	Өөрчлөлт, өмнөх оны мөн үеэс (₮)	Нийт активт эзлэх жин (хувиар)
Нийт актив	36.5	37.3	0.8	3.8	100.0
Банкны нөөц	4.1	3.2	-0.9	-1.2	8.6
ТБҮЦ	7.7	8.7	1.1	4.8	23.2
Гадаад актив	3.2	3.4	0.2	0.8	9.0
ЗГ-ын авлага	1.7	1.9	0.2	0.4	5.1
Үнэт цаас	0.8	0.6	-0.2	0.1	1.7
Зээл	15.8	16.3	0.5	-0.03	43.5
Бусад	3.4	3.3	-0.1	-1.0	8.8

Эх сурвалж: Монголбанк

**Дүрслэл 2. Банкны системийн активын бүтэцэд гарч буй өөрчлөлт (2020.03.31-2021.03.31)**



Эх сурвалж: Монголбанк

**I. ТӨВ БАНКНЫ ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА**

Нээлттэй захын үйл ажиллагаа буюу Төв банкны үнэт цаас (ТБҮЦ)-ны арилжаа нь Монголбанкны мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгсэл юм. Иймд ТБҮЦ-ны анхдагч захын арилжаанд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа банкууд оролцох боломжтой бөгөөд арилжааны төрлийг Монголбанкнаас арилжаа хийх бүрт зарладаг. Тайлант хугацаанд бодлогын хүү 6 хувийн түвшинд хадгалагдсан бөгөөд Монголбанкнаас 28 хоногтой ТБҮЦ-ыг долоо хоног бүрийн Даваа гаригт тогтмол хүүгээр, хэмжээ хязгаарлахгүй, 196 хоногтой ТБҮЦ-ыг 2 долоо хоногт нэг удаа Лхагва гаригт хэмжээ хязгаарлаж, хүүгээр өрсөлдөх хэлбэрээр тус тус арилжаалж байна.

2021.03.31-ний өдрийн байдлаар ТБҮЦ-ны нийт үлдэгдэл 8,695.3 тэрбум төгрөг байгаа бөгөөд үүнээс 8,460.3 тэрбум төгрөг 28 хоногтой үнэт цаасанд, 235.0 тэрбум төгрөг 196 хоногтой үнэт цаасанд тус тус байршиж байна (Дүрслэл 1). Энэ нь ТБҮЦ-ны нийт үлдэгдэл оны эхнээс 1064.4 тэрбум төгрөг буюу 12.2 нэгж хувиар, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4,793.5 тэрбум төгрөг буюу 81.4 нэгж хувиар тус тус өссөн үзүүлэлт юм (Хүснэгт 2).

Ингэснээр банкны системийн активд ТБҮЦ-ны эзлэх хувь 23.2 хувь болж оны эхнээс 2.2 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 11.6 нэгж хувиар тус тус өсчээ (Дүрслэл 2).


**II. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА**

2017 оны 11-р сараас хойш Монгол Улсын Засгийн газраас дотоодын зах зээлд шинээр нээлттэй үнэт цаас арилжаалаагүй байна. Үүний үр дүнд ЗГҮЦ-ны үлдэгдэл 1103.1 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 262.3 тэрбум төгрөгөөр буюу 23.8 нэгж хувиар буурсан байна.


**Хүснэгт 3. Банкны системийн нөөцийн өөрчлөлт (2020.12.31-2021.03.31)**

Үзүүлэлт	Нийлүүлсэн /тэрбум ₮/	Татсан /тэрбум ₮/
<b>ЗГЦЗ</b>		<b>943.3</b>
ЗГҮЦ		
<b>ГЦА</b>	<b>1866.5</b>	
Алт худалдан авалт	405.3	
Валют арилжаа	1378.0	
Төв банкны своп арилжаа	83.2	
<b>Гүйлгээнд байгаа мөнгө</b>		<b>14.5</b>
Бусад хүчин зүйлс		85.1
<b>ТБҮЦ</b>		<b>1064.4</b>
Овернайт хадгаламж	100.5	
Репо санхүүжилт		129.1
<b>Төгрөгийн харилцахын өөрчлөлт</b>	<b>1967.0</b>	<b>2236.4</b>

Эх сурвалж: Монголбанк

**Дүрслэл 3. ГВАН-ийн хэмжээ, өөрчлөлт (Сая \$, 2020.12.31-2021.03.31)**


Эх сурвалж: Монголбанк

**Дүрслэл 4. Төгрөгийн заавал байлгах нөөцийн шаардлага, түүний хангалт (Тэрбум ₮, 2020.12.31-2021.03.31)**


Эх сурвалж: Монголбанк

**III. БАНКНЫ СИСТЕМ ДЭХ НӨӨЦИЙН ӨСӨЛТӨД НӨЛӨӨЛЖ БҮЙ ХҮЧИН ЗҮЙЛС**


2021 оны 1-р улиралд ТБҮЦ-ны нийт үлдэгдэл 1,064.4 тэрбум төгрөгөөр өссөн шалтгааныг банкны систем дэх нийт нөөцөд нөлөөлөгч хүчин зүйлсийг ашиглан тайлбарлая.

Банкны системийн нийт нөөцийн өсөлтийн 92.8 хувийг Гадаад цэвэр активын өөрчлөлт тайлбарлаж байгаа бол бууралтын 49.5 хувийг ТБҮЦ-ны өсөлт, 43.8 хувийг Засгийн газрын Төрийн сангийн нэгдсэн данс (ТСНД)-аар татсан нөөц тус тус тайлбарлаж байна (Хүснэгт 3).


Эдийн засгийн агуулгаар нь дээрх өөрчлөлтийг тайлбарлавал:

- ❑ Монголбанкнаас Гадаад валютын улсын нөөц (ГВУН)-ийг нэмэгдүүлэх зорилгоор алт худалдан авалтаар нийт 405.3 төгрөг, гадаад валют худалдаж авснаар 1,378.0 тэрбум төгрөг, своп арилжаагаар 83.2 тэрбум төгрөгийг тус тус нийлүүлжээ. Эдгээрийн үр дүнд ГВУН энэ оны 3-р сарын байдлаар 4.8 орчим тэрбум ам.долларт хүрч, оны эхнээс 240.4 сая доллараар буюу 5.3 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 680.4 сая доллараар буюу 16.6 нэгж хувиар нэмэгдсэн байна. (Дүрслэл 3).
- ❑ Засгийн газрын орлого цэвэр дүнгээр 943.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, банкны системээс тус дүнгээр нөөц татагдсан байна.
- ❑ Монголбанкнаас оны эхэн үед Эрдэнэс бонд, ипотек, репо арилжаа зэрэг санхүүжилтийг банкуудад олгосон нь нөөцийн өсөлтийн тодорхой хувийг бүрдүүлж байна.
- ❑ Засгийн газраас 2017 оны 11 сараас хойш анхдагч захад үнэт цаас зарлаагүй, тодорхой бус байдал буураагүй, хөл хорио тавьсантай холбоотойгоор банкуудын зээл олгох хэвийн үйл ажиллагаа саарсан зэргээс шалтгаалан банкууд илүүдэл нөөцөө ТБҮЦ-нд байршуулсаар байх хандлага ажиглагджээ.

**Заавал байлгах нөөц:** Төв банкны тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу Монголбанкнаас банкны заавал байлгах нөөц (ЗБН)-ийн шаардлагыг тогтоож, түүнд хяналт тавьж ажилладаг. Өмнөх оны Мөнгөний бодлогын хороогоор төгрөгийн ЗБН-ийн хувь хэмжээг шат дараалалтайгаар 4.5 нэгж хувиар бууруулсан. Ингэснээр 2021 оны 1-р улиралд банкны системийн төгрөгөөр ЗБН дунджаар 1.13 их наяд төгрөгөөр тогтоогдсон бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 532.6 тэрбум төгрөгөөр буюу 32.0 нэгж хувиар буурсан үзүүлэлт байна. Харин валютаар ЗБН тайлант хугацаанд дунджаар 1.22 их наяд төгрөгөөр тогтоогдож, өмнөх оны мөн үеэс 72.6 тэрбум төгрөг буюу 6.3 нэгж хувиар өссөн байна (Дүрслэл 4).

**Дүрслэл 6. Банк хоорондын захын төгрөгийн арилжааны хэмжээ (Тэрбум ₮, 2020.Q1-2021.Q1)**


Эх сурвалж: Монголбанк


**Дүрслэл 7. Банк хоорондын захын төгрөгийн арилжааны дундаж хугацаа (Хоногор, 2020.12.31-2021.03.31)**


Эх сурвалж: Монголбанк


**Хүснэгт 4. Хоёрдогч захын төгрөгийн арилжаанд эзлэх хэмжээ (Хувиар)**

Үзүүлэлт	2020.Q1	2021.Q1
Repo (ТБҮЦ)	18.0%	39.9%
Repo (ЗГҮЦ)	0.0%	0.0%
Шууд (ТБҮЦ)	56.9%	27.3%
Шууд (ЗГҮЦ)	0.0%	0.0%
Овернайт	19.3%	15.5%
Хадгаламж	5.8%	17.3%
Нийт(тб ₮)	4,411.7	2,078.8

Эх сурвалж: Монголбанк

**Дүрслэл 8. MONIA индекс (Хувиар, 2020.12.31-2021.03.31)**


Эх сурвалж: Монголбанк

**IV. БАНК ХООРОНДЫН ЗАХЫН АРИЛЖАА**
**Дүрслэл 5. Банк хоорондын захын арилжааны хүү (Хувиар, 2020.12.31-2021.03.31)**


Хүүний коридор

Эх сурвалж: Монголбанк

Төв банкаар дамжин хийгдэж буй банк хоорондын захын арилжааг төгрөг болон валютын зах тус бүрээр авч үзвэл:

1) 2021 оны 1 дүгээр улиралд банк хоорондын **төгрөгийн** захад нийт 2,078 тэрбум төгрөгийн дүн бүхий 319 хэлцлийг 6.2 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр, 6.8 хоногийн дундаж хугацаатайгаар байгуулжээ (Дүрслэл 5,6,7). Банк хоорондын төгрөгийн захад хийгдсэн нийт хэлцлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.1 дахин буурсан бол нэг хэлцлийн дундаж хэмжээ 19.8 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 12.5 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлт байна. Энэ нь нэг талаас КОВИД-19 цар тахлын улмаас хөл хорио тогтоосноор эдийн засгийн идэвхжилийг бууруулж тайлант хугацаанд банкуудын нөөцөд томоохон хэлбэлзэл үүсээгүй, нөгөө талаас системийн бүтцийн илүүдэл өндөр хэвээр байгаагаар тайлбарлагдаж байна.

Мөн арилжааны бүтцийг авч үзвэл нийт арилжаанд ТБҮЦ-ыг барьцаалан хийж байгаа репо хэлцэл 39.9%, ТБҮЦ-ны шууд хэлцэл 27.3%, овернайт хэлцэл 15.5%, банк хоорондын хадгаламж 17.3%-ийг тус тус бүрдүүлж байна. Банк хоорондын репо хэлцэл нь харилцагчийн эрсдэл багатай тул нийт арилжаанд репо хэлцэл давамгайлж байна (Хүснэгт 4).

**Банк хоорондын овернайт арилжааны дундаж (MONIA) индекс**


Монголбанкнаас зах зээлийн суурь хүүний мэдээллийг олон нийтэд нээлттэй хүргэх зорилгоор MONIA индексийг [цахим хуудсаараа](#) дамжуулан мэдээллэдэг бөгөөд энэ нь банк хооронд хийгдсэн барьцаагүй овернайт хэлцлийн жигнэсэн дундаж хүү юм. 2021 оны 1-р улиралд MONIA индекс нь дунджаар 6.3 хувийн түвшинд хадгалагдсан байна (Дүрслэл 8).

**Хүснэгт 5. Банк хоорондын төгрөгийн захын арилжааны төвлөрөл\***  
**(Тэрбум ₮, 2020.12.31-2021.03.31)**

Оролцогч Талууд	Зээлдэгч тал			
	A(1)	A(2)	A(3)	
Зээлдүүлэгч тал	A(1)	357.0	631.3	159.6
	A(2)	21.2	28.0	98.4
	A(3)	40.9	44.4	332.5

\*Тайлбар: Банкны системд эзлэх активаар нь эхний 3 банкыг A(1), дараагийн 3 банкыг A(2), үлдсэн банкуудыг A(3) гэж тэмдэглэв.

Эх сурвалж: Монголбанк

**Дүрслэл 9. Банкуудын зах зээлд эзлэх хэмжээнээс хамаарсан арилжаанд орох хандлага (2020.12.31-2021.03.31)\*\***


\*\*Тайлбар: Дүрсийн эзэлхүүнээр банкны системд оролцогч A(1), A(2), A(3) ангиллын банкуудын активын хэмжээг харуулсан бөгөөд ногооноор зээлдүүлэгч талыг, улаанаар зээлдэгч талыг тус тус дүрслэв.

Эх сурвалж: Монголбанк

**Хүснэгт 6. Банк хоорондын валютын захын арилжаа (Арилжааны төрлөөр)**  
**(Тэрбум ₮, 2020.12.31-2021.03.31)**

Арилжааны төрөл	Своп хэлцэл	Спот хэлцэл (Захын арилжаа)	Спот хэлцэл (Цахим арилжаа)	Нийт	
2021	1	30.9	19.9	54.3	105.1
	2	10.0	28.8	5.0	43.8
	3	8.4	52.4	-	60.8
I дүгээр улирал нийт	49.3	101.1	59.3	209.7	

Эх сурвалж: Монголбанк

**Хүснэгт 7. Банк хоорондын валютын захын арилжаа (Валютын төрлөөр)**  
**(Тэрбум ₮, 2020.12.31-2021.03.31)**

Валютын төрөл	USD	CNY	EUR	RUB	
2021	1	100.8	3.1	1.2	-
	2	36.3	6.2	1.1	0.2
	3	49.7	5.6	5.5	-
I дүгээр улирал нийт	186.7	14.9	7.9	0.2	

Эх сурвалж: Монголбанк

Банкуудын активын хэмжээнээс хамааруулан банк хооронд хийгдэж байгаа арилжаа (buy or sell side)-г дүрслэл 9, болон хүснэгт 5-д авч үзлээ.

**(1) 2021 оны 1 дүгээр улиралд:**

- A(1) ангилалд байгаа банкууд хамгийн их буюу 103 удаагийн гүйлгээгээр 1147.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон бөгөөд үүнээс ижил ангиллын банканд 357.0 тэрбум төгрөгийн, A(2) ангиллын банканд 631.3 тэрбум төгрөгийн, A(3) ангиллын банканд 159.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон байна.
- A(2) ангилалд байгаа банкууд 33 удаагийн гүйлгээгээр 147.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон бөгөөд 53 удаагийн 703.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг авчээ.
- A(3) ангилалд байгаа банкууд 115 удаагийн гүйлгээгээр 417.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосноос ижил ангиллын банканд 332.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгоод байна.

**(2) Дээрх арилжааны хандлагаас хамааран дараахь дүгнэлтүүд гарч байна.**

- A(1) ангилалд байгаа банкууд ижил болон A(2) хэмжээтэй банканд зээлдүүлэх хандлагатай байдаг бол A(3) банкуудаас хямд эх үүсвэр татах хандлагатай байна.
- A(2) ангилалд байгаа банкууд банк хоорондын захад зээлдүүлэгчээр оролцох хандлага сул бөгөөд нөөцийн хэлбэлзлээс хамааран зах зээлийн томоохон оролцогчдоос санхүүжилт татах сонирхолтой байна (Мөн томоохон банкуудын нөөцийн илүүдэл нөлөөлдөг).
- A(3) ангилалд байгаа банкууд банк хоорондын захаас нөөц зээлэх хандлагатай байдаг бөгөөд ингэхдээ ихэвчлэн ижил хэмжээтэй банктай хэлцэл байгуулдаг байна.

2) Банк хоорондын валютын захад энэ оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 226 гүйлгээгээр сард дунджаар 69.9 тэрбум төгрөгийн дүн бүхий хэлцлийг банкууд хоорондоо байгуулжээ. Ингэхдээ арилжааг хэлцлийн төрлөөр авч үзвэл своп хэлцлээр 49.3 тэрбум төгрөгийн, спот хэлцлээр 160.4 тэрбум төгрөгийн дүн бүхий арилжааг хийсэн байна (Хүснэгт 6).

Банк хоорондын валютын арилжааг валютын төрлөөр нь авч үзвэл 186.7 тэрбум төгрөгийн дүн бүхий ам.доллар, 14.9 тэрбум төгрөгийн дүн бүхий юань, 7.9 тэрбум төгрөгийн дүн бүхий евро, 0.2 тэрбум төгрөгийн дүн бүхий рублийн арилжааг тус тус хийжээ (Хүснэгт 7).